

**ХХЗХ-НЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 12 дугаар сарын 25 өдөр

Улаанбаатар хот

№	Зорилго	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв /мян. т/	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хэрэгжилт
1	2	3	4	5	6	7
1.	Авлигын эсрэг тогтоомжийн хэрэгжилтийг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	<p>1.1.Хорооны ХАСХОМ гаргах албан тушаалтны 2022 оны мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах, холбогдох мэдээ тайланг, АТГ-т хүргүүлэх арга хэмжээг авах</p> <p>1.2 Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг АТГ-аар хянуулах, хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилох, дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох</p>	<p>2 дугаар сарын 28</p> <p>Тухай бүр</p>	<p>-</p> <p>-</p>	<p>-Албан хаагчдын 2022 оны ХАСХОМ-ийг гаргуулж, мэдээ, тайланг нэгтгэн АТГ-т хүргүүлсэн байх</p> <p>-Нийтийн албанд томилогдох иргэний ХАСУМ-ийг АТГ-аар хянуулсан байх -Дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилсон байх -Дүгнэлтүүд нээлттэй, ил тод болсон байх</p>	<p>Авлигын эсрэг хуулийн 11.3 дахь хэсэгт заасны дагуу тус Хорооны албан тушаалтны 2022 оны ХАСХОМ-ийг гаргуулж, мэдээ тайланг нэгтгэн АТГ-т 2023.02.27-ны өдрийн 01/243 тоот албан бичгээр хүргүүлэв. ХХЗХ-ны Хуулийн хэлтсээс албан хаагчдад "2022 оны ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэхэд анхаарах асуудал" сэдвээр сургалтыг 2023.01.06-ны өдөр зохион байгуулсан. Тус Хорооны 79 албан тушаалтан 2022 оны ХАСХОМ-оо хуулийн хугацаанд шинэчлэн гаргав.</p> <p>Нийтийн албанд томилогдох иргэний ХАСУМ-ийг АТГ-аар хянуулж, ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилж байна. ХХЗХ-ны хэмжээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар 20 иргэний ХАСУМ-ийг АТГ-т хянуулж, ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилсон. ХАСУМ хянуулсан жагсаалтыг Хорооны i.crc.gov.mn</p>

1.3.Албан тушаалд томилсон хүний нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох

Тухай бүр

-

-Ажилд томилсон тушаал, шийдвэрийн жагсаалт ил тод, нээлттэй мэдээлэгдсэн байх

цахим хуудас болон “Шудрага ёс-хөгжил дэвшилд” мэдээллийн самбараар олон нийтэд мэдээлэв. <https://www.crc.gov.mn/pages/show/avligaas-urdchilan-sergijleh-soyon-gegeer-leh-azhillagaa>

Тус Хорооны хүний нөөцийн бүртгэл буюу албан хаагчдын шилжилт хөдөлгөөний мэдээг [crc.gov.mn](https://www.crc.gov.mn)-ээр тогтмол мэдээлж байна.

<https://www.crc.gov.mn/pages/show/azhiltan-alban-haagchdyn-shilzhilt-h-d-lg-nij-talaarh-medeelel>

1.4.Хууль, журамд заасан үндэслэлээр албан хаагчдаас ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх мэдэгдэл, тайлбарыг гаргуулж ажиллах

Тухай бүр

-

-Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх мэдэгдэл, тайлбарыг хуульд заасан үндэслэлээр гаргуулж, мэдүүлэг бүрдүүлэлтийн системд бүртгэх, холбогдох арга хэмжээг авч ажилласан байх

Хорооны удирдлага болон албан хаагчдаас захиргааны шийдвэр гаргах, гэрээ байгуулах, худалдан авах ажиллагаанд оролцох зэрэг хуульд заасан үндэслэлээр ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх мэдэгдлийг тухай бүр гарган ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар удирдлага болон албан хаагчдаас гаргасан 118 ашиг сонирхлын мэдэгдлийг хүлээн авч мэдүүлэг бүрдүүлэлтийн програмд бүртгэсэн.

2.	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>2.1.АТГ-аас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл теле зохиомж, зурагт хуудас, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээ /фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг/, лед дэлгэц, сурталчилгааны самбар зэрэгт байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн байх</p>	Тухай бүр	-	<p>-Үр дүнг тооцож тайлагнасан байх /түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо/ -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх</p>	<p>АТГ-аас санаачилсан “Авлигын эсрэг аян”-д нэгдэж, аяныг crc.gov.mn цахим хуудас, харилцаа холбооны зохицуулах хороо фэйсбүүк хуудас, цахим мэдээллийн самбар, Шудрага ёс-хөгжил дэвшилд мэдээллийн самбарт тус тус байршуулж, мэдээлэн сурталчлав. https://www.crc.gov.mn/articles/avligyn-esreg-ayand-negde/mn</p>
		<p>2.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах</p>	2-3 дугаар улирал	-	<p>2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх</p>	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх хүрээнд Хорооноос "Авлигын эсрэг нэгдье", "Авлигыг таслан зогсооход хүн бүрийн оролцоо чухал" агуулга бүхий постерыг хийж, Харилцаа холбооны зохицуулах хорооны авлигын эсрэг байр суурийг илэрхийлж олон нийтэд түгээсэн. Мэдээллийн Шудрага ёс-хөгжил дэвшилдсамбар болон цахим мэдээллийн самбар, дэйж хуудсаар сурталчилсан.</p> <p>https://www.facebook.com/crcmongol/posts/pfbid02jDSDT6UFiw5Cf33agnfRJjy56TRJBFVjsyH3ZDsyTPiAGpsegwiWLcWnGZPPST9ol</p>
		<p>2.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шудрага ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах</p>	1-4 дүгээр улирал	-	<p>-Мэдээллийг сар бүр шинэчлэх</p>	<p>“Шудрага ёс-хөгжил дэвшилд” мэдээллийн самбарыг захиалан хийлгэж, мэдээллийн самбарын мэдээллийг тогтмол шинэчилж, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд хориглох</p>

					<p>үйлдэл, авлигын хэлбэрүүд, авлига-шудрага ёс, авлигыг мэдээлэх утас 110 зэрэг сурталчилгааны материал, Хорооны 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, 2023 онд хянуулсан ХАСУМ-ийн жагсаалт зэргийг цахим хуудас, мэдээллийн самбараар сурталчлав.</p>
	<p>2.4.Хорооны үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байлгахад чиглэсэн ёс зүй, шудрага байдлыг уриалсан агуулга бүхий /шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээр сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх</p>	<p>1-4 дүгээр улирал</p>	<p>1.0</p>	<p>-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх -Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг/, лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх -Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх</p>	<p>Тус Хорооны үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байлгахад чиглэсэн ёс зүй, шудрага байдлыг уриалсан агуулга бүхий зурагт хуудас, постерыг гэрээний үндсэн дээр "Кодворкс" ХХК-аар гүйцэтгүүлж Хорооны Шудрага ёс, хөгжил дэвшилд мэдээллийн самбар, Харилцаа холбооны зохицуулах хороо пэйж хуудас, цахим самбар зэргээр сурталчлав.</p> <p>https://www.facebook.com/crcmongol/posts/pfbid02jDSDT6UFiw5Cf33agnfRJy56TRJBfVjsyH3ZDsyTPiAGpsegwiWlcWnGZPPST9ol</p>
<p>3. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах</p>	<p>3.1.Нийт албан хаагчид болон шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх</p>	<p>2-4-р улирал</p>	<p>-</p>	<p>Нийт албан хаагчид болон шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамруулсан байх</p>	<p>ХХЗХ-ны нийт албан хаагчдад авлигаас урьдчилан сэргийлэх анхан шатны сургалтыг АТГ-аас 2022 оны 05 дугаар сард зохион байгуулсан. 2023 оны эхний хагас жилд шинээр томилогдсон албан хаагчдыг 2023 оны 3-4-р улиралд сургалтад хамруулахаар</p>

					<p>төлөвлөсөн. Хуулийн хэлтсээс албан хаагчдад "2022 оны ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэхэд анхаарах асуудал" сэдвээр сургалтыг 2023.01.06-ны өдөр зохион байгуулсан. Мөн 2022-2023 онд нийтийн албан тушаалд томилогдсон 12 албан хаагчийг АТГ-ийн олон нийтийн төвд 2023.11.10-ны өдөр зохион байгуулсан авлига, ашиг сонирхлын зөчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулсан /хариуцсан комиссар Жамьянчойжил/. Мөн албан хаагчдыг Удирдлагын академийн Төрийн албан хаагчдад зориулсан "Авлигаас ангид төрийн алба" 1-р түвшний сургалтад 2023 оны 12 дугаар сарын 09-12-ны хооронд хамруулсан.</p> <p>Тус Хорооноос авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар иргэд, олон нийт, тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдээлж байна. https://www.crc.gov.mn/pages/show/avligyn-esreg-arga-hemzheenij-2022-ony-t-l-vl-g-nij-bielelt</p>	
		3.2.Хорооны орон нутаг дахь төлөөлөгчид, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах	3-4-р улирал	-	-Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх	
4.	Авлигын эсрэг үйл ажиллагаанд	4.1.Бусад иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг	1-4-р улирал	-	-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх -Авлигыг мэдээлэх	Тус Хорооноос иргэн, хуулийн этгээдтэй байгуулж буй гэрээнд гэрээг байгуулах харилцаанд авлигаас ангид байх, гэрээг

олон нийтийн хяналтыг бий болгох	тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах			үүргийг тусгасан байх -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах -Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх	байгуулахтай холбогдуулан авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан нь тогтоогдвол гэрээг цуцлах, түүний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэрээ байгуулахтай холбоотой авлигад өртсөн байж болзошгүй мэдээллийг АТГ-ын 110 утсанд мэдээлэх зэрэг асуудлыг тусган байгуулж байна.
	4.2."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх	1-4-р улирал	-	-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх -Сургалт, мэдээлэл авсан байх -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан, зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлсэн байх	Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмын хүрээнд тус Хорооноос Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган тус Хорооны CRC.GOV.MN цахим хуудаст холбогдох мэдээллүүдийг цаг хугацаанд нь байршуулж, шинэчлэн ажилласан.
5. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	5.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүрээнд харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгох, сунгах, өөрчлөлт оруулах, зэрэг үйл ажиллагааг цахимжуулах, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авах	1-4-р улирал	-	-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх	Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажиллагааг үе шаттай хэрэгжүүлж байна. Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгах хүсэлтийг customer.crc.gov.mn цахим системээр дамжуулан хүлээн авч, шийдвэрлэж байгаа болно. https://www.crc.gov.mn/pages/show/electronic-license-platform/mn
	5.2.Салбарын хэмжээнд			-2-оос доошгүй арга	Харилцаа холбооны салбарт үйл

авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх

2-4-р улирал

2.0

хэмжээ зохион байгуулсан байх -хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх

ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох хүрээнд авлига ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан нөхцлийг тодорхойлох зорилгоор Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг МХХ-оор гүйцэтгүүлж хүлээн авсан. Судалгааны тайланг 2023.12.22-нд хүлээн авсан бөгөөд тайланг үндэслэн холбогдох сургалт, сурталчилгааны ажлыг 2024 оны төлөвлөгөнөөд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Судалгааны дүнг танилцуулах сургалт, хэлэлцүүлгийг Зөвлөх багтай тохиролцсоны дагуу 2024 оны 1 дүгээр сард нийт албан хаагчдад зохион байгуулж, олон нийтэд болон салбарын хэмжээнд мэдээлэхээр төлөвлөсөн.

5.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах

3-4-р улирал

2.0

-Сэтгэл ханамжийн судалгааг хийж, үр дүнг тооцсон байна.

ХХЗХ-ны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.3-т "Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах" -аар төлөвлөсний дагуу хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа хийлгэх, сургалт зохион байгуулах Зөвлөх үйлчилгээний Г/23128 тоот гэрээг Монголын хуульчдын холбоотой байгуулан ажилласан. Гэрээний дагуу судалгааны тайланг хүлээн авсан. Тайланг хавсаргав. Тайланг үндэслэн тодорхой арга хэмжээнүүдийг 2024 оны авлигын

<p>6. Хорооны удирдлагаас авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл санаачлага өрнүүлэх</p>	<p>6.1.Удирдлагаас 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1 дүгээр улиралд, хэрэгжилтийн явцыг 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор, хэрэгжилт, хүрсэн үр дүнг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийт албан хаагчдадаа танилцуулах</p>	<p>1-4-р улирал</p>	<p>-</p>	<p>-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх -Албан хаагчдаас авлигын эсрэг үйл ажиллагааны талаар гаргасан санал, санаачлагыг хэлэлцсэн байх</p>	<p>эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Тус Хорооны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг АТГ-аас 2023.02.14-ний 01/2912 тоот “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тухай” албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу ирүүлсэн саналыг тусган боловсруулж, ХХЗХ-ны даргаар 2023.01.23-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөг Хорооны цахим хуудаст https://www.crc.gov.mn/pages/show/avligataj-temceh-ndesnij-h-t-lb-rjig-heregzh-leh-arga-hemzheenij-t-l-vl-g-tajlan линкээр байршуулав. Хорооны даргын зүгээс нийт албан хаагчдад Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг хүргүүлж, төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах талаар биечлэн үүрэг, зөвлөмж хүргүүлсэн.</p>
	<p>6.2.Авлигатай тэмцэх газраас ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусган, дүрмийг баталж, хэрэгжүүлэх</p>	<p>3 дугаар сарын 30</p>	<p>-</p>	<p>-Саналыг тусгасан байх</p>	<p>Тус Хорооны даргын 2019 оны А/276 дугаар тушаалын хавсралтаар Харилцаа холбооны ажилтан, албан хаагчдын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрмийг баталсан бөгөөд дүрмийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах явцад тус Хорооны ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг тодорхой болгох шаардлагыг үндэслэн Ёс зүйн</p>

					зөвлөлийн ажиллах журмын төслийг боловсруулж, ХХЗХ-ны даргын 2023 оны А/80 дугаар тушаалаар батлуулсан. Мөн 2023 оны 9-р сард нийт албан хаагчдаас санал авч Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлав.	
		6.3.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачлага уриа, аянд нэгдэх	Тухай бүр	-	Авлигын эсрэг санал, санаачлага, аянд нэгдсэн байх	АТГ-аас санаачлан зохион байгуулж байгаа “Авлигын эсрэг аян”-д нэгдэж, аяны мэдээллийг цахим хуудсаар мэдээлж, сурталчилж байна.. https://www.crc.gov.mn/articles/avlig-yn-esreg-ayand-negde/mn
7.	Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	7.1.Авлигын эсрэг хууль болон Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд цахим хуудаст байршуулж, иргэд, олон нийт танилцах боломжоор хангах	1-4-р улирал	-	Хуулийг хэрэгжүүлж, иргэд олон нийтийг мэдээллээр хангасан байх	Авлигын эсрэг хууль, Шилэн дансны тухай хуулийн 6, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг тус Хорооны crc.gov.mn , shilendans.gov.mn цахим хуудсаар хугацаанд нь тогтмол мэдээлж хэвшсэн.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО